



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 онь 01 сарын 19 өдөр

Дугаар А/19

Номгон

Хөдөө аж ахуйн кластер төслийн багц ажлуудад 2024 онд батлагдсан төсөвт өртгийг хуваарилан зарцуулах тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус тус заасан "Тогтвортой хөдөө аж ахуй" зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVI. 1.9, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай" А-33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн XVII.1.12 дугаарт батлагдсан 12 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хавсралтаар баталсан 1000 тн хүчин чадалтай мах, ногооны зоорь байгуулах, Ногоон тэжээлийн үйлдвэр байгуулах ажлуудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVI. 1.9 дугаарт батлагдсан "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах" төслийн энэ онд батлагдсан 2,000.0 сая төгрөгийг энэхүү захирамжийн хавсралтын дагуу хуваариар баталж төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

842311995

2.

3. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах" төслийн батлагдсан ажлуудын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай

ДАРГА ~~Д.Мөнхсайхан~~ Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дүгээр сарын
19-ний өдрийн 7119 дүгээр захирамжийн
хэвсрэл



ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРИЙН КЛАСТЕР
БАЙГУУЛАХ ЖАГСААЛТ

Багц	Төслийн нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Гэрээний дүн	Авсан санхүүжилт	2024 онд санхүүжих дүн
1	Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил	2022	2024	2,584.78	1,584.8	1,000.0
2	Мах ногооны зоорь	2022	2024	4,869.19	3,074.9	1,000.0
	НИЙТ			7,454.0	4,659.7	2,000.0

оОо